



СҮХБААТАР АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/22

Баруун-Урт сум

Байгууллагын тэмдэг, хэвлэмэл хуудас
хариуцах албан тушаалтныг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6.7, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам-ын 2.2.1.11, аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулах тухай" А/664 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцах албан тушаалтнаар 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Архив, бичиг хэргийн эрхлэгчийг томилсугай.
2. Байгууллагын тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, бүртгэл тооцоог зааврын дагуу хэрэгжүүлж ажиллахыг байгууллагын тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцах албан тушаалтанд даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Б.Галсанжамц)-д үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ө.ТАЙВАНСАНАА

2224010075